

МУИС-ИЙН УТСОУХНУС-ИЙН ХӨТӨЛБӨРИЙН БАКАЛАВРЫН ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

2024-2025 оны хичээлийн жилийн намрын улирал

МУИС-ийн УТСОУХНУС-ийн Олон улсын харилцааны тэнхимээс жил бүр зохион байгуулж буй Оюутны эрдэм шинжилгээний хурал 2024 оны 11 дүгээр сарын 20-ны 11:00 цагт /Лхагва гараг/ МУИС-ийн хичээлийн V байрны 203 тоотод зохион байгуулагдана.

Зорилго: Олон улсын харилцаа, улс төр, нийтийн удирдлагын чиглэлээр онол практикийн ач холбогдол бүхий судалгааны шинэ бүтээл, үзэл санааг хөгжүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, харилцан санаа бодлоо чөлөөтэй солилцох, оюутны эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжихэд чиглэгдэнэ.

Хамрах хүрээ:

- ОУХ-ны хөтөлбөрөөр бакалаврын түвшинд суралцаж буй оюутнууд

Бүртгэл:

Илтгэлийн хураангуйг 2024 оны 11 дүгээр сарын 19-ны 16:00 цаг хүртэл дараах цахим хаягаар илгээнэ: ninjin.g@num.edu.mn

Илтгэлд тавигдах шаардлага:

- Шинжлэх ухааны үндэслэлтэй байх
- ЭШ-ний бичлэгийн хэлбэрээр бичигдсэн байх
- Онолын болон судалгааны материалын боловсруулалт хийсэн байх
- Шинэлэг санааг дэвшүүлсэн, эрэл хайгуул хийсэн байх
- Практик ач холбогдолтой байх
- Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, үр дүнд хүрсэн байх

Эрдэм шинжилгээний бүтээл нь дараах хэсгүүдтэй байна.

- Бүтээлийн нэр
- Оролцогчийн овог, нэр, хаяг, электрон шуудангийн хаяг
- Товч хураангуй
- Түлхүүр үг
- Оршил
- Үндсэн хэсэг /судлагдсан байдал, судалгааны арга зүй, судалгааны үр дүнг дүгнэсэн дэд хэсгүүд эсвэл сэдвээс хамаарсан бусад дэд сэдвүүд байж болно/
- Дүгнэлт
- Зөвлөмж
- Ном зүйн жагсаалт
- Хавсралт

Илтгэл:

- Илтгэлийн эхэнд илтгэлийн нэр/сэдэв/, зохиогчийн бүтэн нэр, анги түвшин, харилцах утас, e-mail хаягийг бичнэ.
- Илтгэлийг хуралд хэлэлцүүлэхдээ Microsoft PowerPoint программаар бэлдэж ирнэ.
- Илтгэл нь хураангуй, түлхүүр үг 5-10, оршил, үндсэн агуулга, зураг хүснэгт, дүгнэлт, ишлэл татсан номын нэрсээс бүрдэнэ.
- Үсгийн фонт: Times New Roman
- Үсгийн хэмжээ: 12
- Мөр хоорондын зай: Single
- Илтгэлийн хэмжээ: А4 форматаар 5-10 нүүр хүртэл

Бүртгэл буюу илтгэлийн хураангуйг хүлээн авах хугацаа:

2024 оны 11 дугаар сарын 19 хүртэл 16:00 цаг

Зохион байгуулах комисс
Олон улсын харилцааны тэнхим